



# CRC POST NEWS

2025

05




## ЭНЭ ДУГААРТ

МОНГОЛ УЛС 5G  
СҮЛЖЭЭГ АЛБАН  
ЁСООР АСААЖ,  
ТЕХНОЛОГИЙН ШИНЭ  
ЭРИНИЙГ ЭХЛҮҮЛЛЭЭ



"ЦАХИМ ОРЧИНД  
ХҮҮХДЭЭ ХАМГААЛЪЯ"  
ТӨСӨЛ ХАМТРАН  
ХЭРЭГЖҮҮЛЭХ САНАМЖ  
БИЧИГ БАЙГУУЛЛАА



ТУРК УЛСАД "WORLD-  
DEF ISTANBUL 2025"  
ЦАХИМ ХУДАЛДААНЫ  
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН  
БАЙГУУЛАГДЛАА



ДЭЛХИЙН ШУУДАНГИЙН  
28 ДАХ ИХ ХУРАЛД  
ТУСГАЙЛАН ЗОРИУЛСАН  
ЧАДАВХЖУУЛАХ  
СУРГАЛТАД ОРОЛЦЛОО



АЗИ, НОМХОН  
ДАЛАЙН ШУУДАНГИЙН  
ХОЛБООНЫ ХУРАЛДААН  
УЛААНБААТАР ХОТОД  
ЗОХИОН  
БАЙГУУЛАГДАНА



ХАРИУЦЛАА ХОЛБООНЫ  
ЭЛСЭЖЦҮҮЛЭХ  
ХЭРЭГ

Метро бизнес төв  
А-блок 5 давхар  
Д.Сүхбаатарын гудамж-13  
Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар 14201-0033



XXIII Хөрөнгийн жил

## МОНГОЛ УЛС 5G СҮЛЖЭЭГ АЛБАН ЁСООР АСААЖ, ТЕХНОЛОГИЙН ШИНЭ ЭРИНИЙГ ЭХЛҮҮЛЛЭЭ



Мобиком Корпораци ХХК

Монгол Улс 5G технологид ашиглах радио давтамжийг олон улсын хэмжээнд 2023 онд баталгаажуулж, бодлого зохицуулалтын орчныг шат дараатайгаар бүрдүүлсэн бөгөөд 2025 оны 05 дугаар сарын 15 өдөр албан ёсоор 5G сүлжээг нэвтрүүлж байна.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь "Радио давтамжийн зурвасыг дараа үеийн хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системд ашиглах тусгай зөвшөөрөл олгох" сонгон шалгаруулалтыг амжилттай зохион байгуулж, өнөөдөр үйлчилгээ эрхлэгчдэдээ тусгай зөвшөөрлийн гэрчилгээг нь 2025.05.16-ны өдөр гардуулан өглөө.

5G сүлжээ нь өндөр хурдны интернэтээр хязгаарлагдахгүй харилцаа холбоо, аж үйлдвэр, боловсрол, эрүүл мэнд, уул уурхай зэрэг олон салбарт хувьсал авчирна.



Юнител ХХК



Скайтел ХХК



Ондо ХХК



Жи Мобайл ХХК





## ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ХӨГЖИЛ-2025\* ФОРУМ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Харилцаа холбооны зохицуулах хорооноос 2025 оны 5-р сарын 09-ний өдөр "Өргөн нэвтрүүлгийн хөгжил-2025" форумыг амжилттай зохион байгууллаа. Форумын үеэр өргөн нэвтрүүлгийн салбарын хөгжлийн чиг хандлага, контент бүтээл үйлдвэрлэл, дамжуулах орчны өөрчлөлт болон технологийн шинэчлэл болон олон улсын хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлд үйлчилгээ эрхлэгчдийн дунд хэлэлцүүлэг өрнүүлж, асуудлыг өргөн хүрээнд хэлэлцлээ.

Форумд гадаад дотоодын телевизүүд, контент бүтээгчид мэргэжлийн холбоод, бодлого боловсруулагч, зохицуулагч байгууллагын төлөөллөөс бүрдсэн 90 гаруй зочид төлөөлөгч оролцов.

Тухайлбал, БНСУ-ын Arirang, MBC Plus, KBC телевиз, контент бүтээл ба түгээлтийн Busan Content Market компани, мөн Magic Image, Character Link, Weo, RoiVisual зэрэг компанийн удирдлага, төлөөллүүд оролцлоо. Үүнээс гадна технологийн чиглэлээр Сингапур улсын Brainstorm, Whiteways Systems, Украины Animagic зэрэг контент бүтээл, платформын компаниудын төлөөлөгчид хүрэлцэн ирсэн. Форумын хүрээнд сүүлийн жилүүдэд хэрэглэгчийн

контент үзэх зан төлөв хурдтай өөрчлөгдөж, сошиал медиа, OTT үйлчилгээ, стриминг платформууд (Netflix, YouTube, TikTok гэх мэт) эрчимтэй нэвтэрч буй энэ үед Монгол Улсын телевизийн өргөн нэвтрүүлгийн зах зээлийн нөхцөл байдал, орлогын хандлага, олон сувгийн дамжуулах үйлчилгээний технологийн хөгжил, эдгээр өөрчлөлт салбарт хэрхэн нөлөөлж байгааг хэлэлцлээ. Мөн дэлхий дахины өргөн нэвтрүүлгийн салбарын зах зээлийн чиг хандлагын талаар олон улсын зөвлөх, судалгааны байгууллагуудын гаргасан тайланд суурилан товч мэдээлэл өгсөн юм.



## "ЦАХИМ ОРЧИНД ХҮҮХДЭЭ ХАМГААЛЪЯ" ТӨСӨЛ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛЛАА



Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн Сан, Харилцаа холбооны зохицуулах хороо, ТЭСО групп "Цахим орчинд хүүхдээ хамгаалъя" төслийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичигт 2025.05.26-нд гарын үсэг зурлаа.

Санамж бичгийн хүрээнд хүүхэд, эцэг эхчүүд болон Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулан цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалтын модуль хөгжүүлж, тэдгээрт мэдлэг олгох, чадавхыг бэхжүүлэх юм.

"Цахим орчинд хүүхдээ хамгаалъя" төслийг Харилцаа холбооны зохицуулах хороо, НҮБ-ын Хүүхдийн сан санаачилсан ба ТЭСО групп дэмжлэг үзүүлж 100,000 ам.долларын санхүүжилт олгохоор боллоо. Нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж хүүхдүүдийн ирээдүйд бодитой хувь нэмэр оруулж байгаа ТЭСО группийн хамт олонд Монголын мянга мянган хүүхэд багачуудын өмнөөс талархал илэрхийлье.





## ШУУДАНГИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН АЖИЛТАН, УДИРДЛАГЫГ МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Харилцаа холбооны зохицуулах хороо, ШУТИС-ийн Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн Мэдээлэл холбооны технологийн сургалтын төвтэй хамтран тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ажилтан, удирдлагыг мэргэшүүлэх ээлжит сургалтыг 2025 оны 4 сарын 28-ний өдрөөс эхлэн 21 хоногийн хугацаанд амжилттай зохион байгууллаа.

Шуудангийн салбарын цогц мэдлэг олгох батлагдсан хөтөлбөрийн дагуу шуудангийн үйлчилгээ эрхлэгчдийн зайлшгүй мэдэх шаардлагатай агуулгын хүрээнд 38 цагийн сургалтын хөтөлбөрийг боловсруулан мэргэшсэн туршлагатай багш, салбарын мэргэжилтнүүд хичээл зааж бэлтгэгдсэн.

Сургалтад 2024-2025 онд тусгай зөвшөөрөл авсан байгууллагын төлөөлөл

хамгийн идэвхтэй хамрагдсан нь шуудангийн зах зээлд өрсөлдөх чадварыг мэргэшсэн хүний нөөц, хүний нөөцийн бодлогоор нэмэгдүүлж байгааг харуулж байна.

Энэхүү сургалтаар олгосон мэдлэгийг бататгах шалгалтыг 2025 оны 5 сарын 24-26-ны хооронд зохион байгуулж, амжилттай төгссөн 22 шууданчдад мэргэжлийн сертификатыг 2025 оны 05 сарын 27-ны өдөр гардууллаа.

Мэргэшүүлэх сургалтыг 2019 оноос эхлэн 5 дахь удаагаа зохион байгуулж, шуудангийн салбарын 125 ажилтан, удирдлагыг мэргэшүүлж, сертификат олгоод байна.



## ТУРК УЛСАД "WORLDDEF ISTANBUL 2025" ЦАХИМ ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

Бүгд Найрамдах Турк Улсын Истанбул хотноо 2025 оны 5-р сарын 13-18-ны өдрүүдэд дэлхийн шуудангийн салбарын шинэ үйлчилгээ, цахим худалдаа, хүргэлтийн үйлчилгээний салбарын технологи, логикийн шийдлүүдийг танилцуулах дэлхийн нэр хүндтэй үзэсгэлэн экспо "Worlddef Istanbul 2025" арга

хэмжээ зохион байгуулагдлаа. Үзэсгэлэнд дэлхийн 50 орны 30,000 оролцогч, 200 илтгэгч, 240 үзэсгэлэнгийн павилон, 500 гаруй шилдэг брэндүүдийн танилцуулга хийгдэж бизнес эрхлэгч, технологийн үйлдвэрлэгч, бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэгч нарын уулзалт хэлэлцүүлгүүд зохион байгуулагдсан юм.







Хэлэлцүүлэг, арга хэмжээний үеэр Цахим худалдааны ирээдүйн чиг хандлага, жижиглэнгийн технологийн шинэчлэл, хиймэл оюун ухаан, хэрэглэгчийн зан төлөвийн өөрчлөлт, олон улсын зах зээлд нэвтрэх стратеги зэрэг сэдвүүдээр илтгэл тавьж Microsoft, Amazon, Alibaba, Trendyol, Jumia, TEMU зэрэг дэлхийн тэргүүлэгч компаниудын удирдах албан тушаалтнууд практик туршлага, шинэ санаа, дата-д суурилсан мэдлэг хуваалцлаа.

Цахим худалдааны технологийн ирээдүйг танилцуулах интерактив үзэсгэлэнгийн талбайд дэлхийн тэргүүлэгч шийдэл нийлүүлэгчидтэй холбогдох боломжтой бөгөөд хөрөнгө оруулагчид, логистикчид, стартапууд, технологийн үйлчилгээ

үүзүүлэгчид болон цахим худалдааны платформын үүсгэн байгуулагчидтай уулзах, хамтран ажиллах боломжийг олгож байгаа нь чухал ач холбогдолтой байсан талаар оролцогчид ярьж байв.

Мөн энэхүү арга хэмжээнд шуудангийн илгээмж бүртгэлийн цахим системийг нийлүүлэгч программ хангамжийн компаниуд, шуудангийн илгээмжийн сав баглаа, боодол үйлдвэрлэгч компаниуд мөн шуудангийн хүргэлтэд ашиглахыг санал болгож буй цахилгаан эко тээврийн хэрэгслийг үйлдвэрлэгч компаниудын төлөөллүүд өөрсдөө танилцуулж үзэсгэлэн, яармагт оролцсон нь онцлог байлаа.



"Worlddef Istanbul 2025" үзэсгэлэн яармагт ХХЗХ-ны Шуудангийн зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн Э.Наранцэцэг, "Улс хоорондын шуудангийн холбоо" ТББ-ын гишүүдийн хамт оролцлоо.





## ДЭЛХИЙН ШУУДАНГИЙН 28 ДАХ ИХ ХУРАЛД ТУСГАЙЛАН ЗОРИУЛСАН ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТАД ОРОЛЦЛОО



Дэлхийн шуудангийн 28 дах удаагийн их хурал Арабын Нэгдсэн Эмират Улсын Дубай хотноо 2025 оны 8-19-ний өдрүүдэд зохион байгуулагдана. Үүнтэй холбогдуулан Ази, Номхон далайн шуудан холбооноос гишүүн улс орнуудыг Дэлхийн шуудан холбооны ээлжит Их хуралд бэлтгэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилготой "Дэлхийн шуудангийн 28 дах Их хуралд тусгайлан зориулсан чадавхижуулах сургалт"-ыг зохион байгууллаа. Сургалтад ХХЗХ-ны Шуудангийн зохицуулалтын газрын мэргэжилтэн Ц.Амгалан оролцлоо. Сургалтад Ази, Номхон далайн бүсийн 39 оролцогч хамрагдсан байна. Сургалтын гол зорилго нь Дэлхийн шуудангийн их хурал, түүний баримт бичгүүдийн талаарх ойлголт, хурлын үйл явц, ач холбогдлын талаар мэдээлэл өгөх, хамтран хэлэлцэх, мөн 28 дахь Их хурлаар хэлэлцэх гол саналуудын талаар мэдлэг олгох байлаа.



Дэлхийн шуудангийн их хурал (Universal Postal Congress) нь Дэлхийн шуудангийн холбоо (Universal Postal Union, UP-U)-ны дээд хэмжээний хурал бөгөөд 192 гишүүн орнуудын шуудангийн салбарын төлөөлөгчид 4 жил тутам цугларч, Дэлхийн шуудан холбооны конвенц, журам, бодлогод өөрчлөлт оруулах, шуудангийн салбарын ирэх жилүүдийн стратегийг хэлэлцэх, Дэлхийн шуудан холбооны Ерөнхий захирал, орлогч захирал, Захиргааны зөвлөл, Шуудангийн ашиглалтын зөвлөл болон Зөвлөлдөх хорооны сонгуулиуд болдог шуудангийн салбарын хамгийн том арга хэмжээ юм.



## ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГУУЛАХ ХҮСЭЛТЭЭ ЦАХИМААР ӨГНӨ ҮҮ

2025 оны эхний хагас жилд тусгай зөвшөөрлийн хугацаа нь дуусч байгаа дараах аж ахуйн нэгжүүд Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 2-т заасны дагуу зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногоос доошгүй хугацааны өмнө зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай өргөдөл, хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу бүрдүүлсэн баримт бичгийн хамт эрх бүхий этгээдэд гаргана гэж заасны дагуу цахимаар илгээнэ үү.

### 2025 ОНЫ 7, 8 ДУГААР САРУУДАД ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА НЬ ДУУСЧ БАЙГАА ШУУДАНГИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУД

№	Зөвшөөрөл	Харилцагч	Дуусах огноо	Тайлбар
1	43400004	Дөлгөөндэлгэрэх ХХК	2025/07/03	Дотоод
2	43200178	Юү ти пи эс онлайн ХХК	2025/07/06	Монгол Улс-БНХАУ
3	43200179	Таруугийн таван улиас ХХК	2025/07/06	Монгол Улс-Франц
4	43200180	Хишиг карго ХХК	2025/07/06	Монгол Улс-БНСУ
5	43200181	Бизнес эволюшн групп ХХК	2025/07/06	Монгол Улс-БНСУ
6	43200182	Болоргоо билэг ХХК	2025/07/06	Монгол Улс-БНСУ
7	43200183	Эйч эйч кэй ложистикс ХХК	2025/07/06	Монгол Улс-БНСУ
8	43200184	Эксим ложистик ХХК	2025/07/06	Монгол Улс-БНХАУ
9	43200074	МК трансворлд ХХК	2025/07/07	Дотоод
10	43200100	Дөлгөөндэлгэрэх ХХК	2025/07/07	Дотоод
11	43200077	Гэрэлт хүрэх оргил ХХК	2025/08/30	Дотоод
12	43200185	Аршгүүр ХХК	2025/08/31	Монгол Улс-Польш Улс
13	43200186	Юү ти пи эс онлайн ХХК	2025/08/31	Монгол Улс-БНТУ







## ШУУДАНГИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИД ЦАХИМ СУРГАЛТЫН СИСТЕМИЙГ АШИГЛАН СУРГАЛТ, МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ БАЙНА


Харилцаа холбооны зохицуулах хорооноос Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэгчдийн хилийн чанад дахь хамтрагч байгууллагуудын ажилтнуудыг цагийн зөрүүгүйгээр сургалтад хамрагдах боломжийг бүрдүүлэх зорилгоор Цахим сургалтын платформыг нэвтрүүлэн ажиллаж байгаа билээ.

Шуудангийн үйлчилгээ эрхлэгч нэвтрэх эрх бүхий <https://crc.gosmart.mn/#/login> холбоосыг үүсгэж, Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, стандарт, технологи ажиллагааны цуврал 4 төрөл 10 видео хичээлүүдийг бэлтгэн оруулаад байна.

Энэхүү программд байгууллага бүрт үндсэн хаяг нээгдсэн бөгөөд ажилтан өөрөө нэмж хаяг бүртгүүлэх боломжтой.

Уг цахим холбоосоор орж, бүртгүүлснээр та бүхэн Харилцаа холбооны зохицуулах хороо, ЦЕГ-Хар тамхитай тэмцэх газар, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар гэх мэт хамтарсан сургалт тогтмол зохион байгуулдаг байгууллагуудын танилцуулга, сургалтын материал, заавар зөвлөгөө, мэдээллийг цахим хэлбэрээр авах боломжтой.

Та бүхэн уг цахим сургалтын системд хандан сургалт, мэдээллийг авч үйл ажиллагаандаа өргөнөөр ашиглана уу.







## ГАР УТАСНЫ ПРОГРАМЫН ТУСЛАМЖТАЙГААР МАРК ЦУГЛУУЛАХ АЖЛЫГ ХЯЛБАРШУУЛЖ БАЙНА

Филателийн дугаарлалтын системийг хөгжүүлэх Дэлхийн нийгэмлэг (WNS)-ээс гар утасны шинэ программыг нэвтрүүлснээр дэлхий даяарх марк цуглуулагчид 120,000 гаруй маркыг худалдан авах, цуглуулах, сонирхсон маркынхаа талаарх мэдээллийг авах боломжтой боллоо.

WNS мэдээллийн сан нь өнөөдрийг хүртэл 200 орчим марк гаргагчдыг төлөөлсөн, марк гаргагчдын өөрсдийнх нь ирүүлсэн мэдээлэлд тулгуурласан 100% цорын ганц нэгдсэн систем юм.

Дэлхийн шуудан холбоо уг программ хангамжийн гар утасны шинэ хувилбар болох WNS Stamps App-ийн тусламжтайгаар марк цуглуулагчид болон марк сонирхогчдыг холбох, мэдээлэл түгээх найдвартай эх сурвалж болж байна.

Шинэ аппликейшн нь вэбд суурилсан WNS мэдээллийн санд байгаа бүх өгөгдлийг хадгалахаас гадна хиймэл оюун ухаан AI-д суурилсан нэмэлт функцтэй бөгөөд хэрэглэгчид утасныхаа камераар марк дээрх тамгыг сканнердаж, таних боломжийг олгож байгаа юм.

UPU-ийн Филателийн хөгжил, баримтат өвийн хөтөлбөрийн менежер Бенжамин Комбс "дэлхийн мянга мянган марк цуглуулагчдын хувьд энэ програм нь тэдний хүсэн хүлээж байсан, сонирхлыг зайлшгүй татах программ байх болно" гэж үзэж байна.

Аппликейшн гарахаас өмнө марк цуглуулагчид аливаа маркийг танихын тулд каталог, томруулдаг шил, гүүгл хайлтын системээс мэдээлэл хайх зэргээс эхлээд маш их цаг хугацаа, эрэл хайгуул зарцуулдаг байсан.

Харин энэхүү програмын тусламжтайгаар дурын маркынхаа зургийг оруулаад уг марктай холбоотой бүх мэдээллийг хэдхэн секундын дотор авч чаддаг болжээ.

Хэрэглэгч програмыг нээж, "ID" таб руу гүйлгэж, утсан дээрээ маркийн зургийг байршуулна. Дараа нь хиймэл оюун ухаанд суурилсан программ хангамж нь зургийг сканнердаж, маркны хэмжээ, элэгдэл цооролт зэргээс хамааран мета өгөгдөлтэй харьцуулдаг юм байна.

## АЗИ, НОМХОН ДАЛАЙН ШУУДАН ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАГДАНА

# APPU

**Asian-Pacific Postal Union**  
*taking posts into the future*



Гүйцэтгэх Зөвлөл (Executive Council – EC) нь Шуудангийн их хурал хооронд Холбооны үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх үүрэгтэй. Бүрэн эрхийнхээ хүрээнд зөвлөл нь жил бүр хуралддаг.

Гүйцэтгэх зөвлөлийн энэ удаагийн хурал Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо 2025 оны 6 дугаар сарын 30-наас 7 дугаар сарын 4-ний өдрүүдэд зохион байгуулагдах гэж байна.

Гүйцэтгэх Зөвлөл нь холбооны бүх гишүүн орнуудаас бүрддэг бөгөөд тус зөвлөлийн үндсэн чиг үүргүүд нь:

- Конгрессоос баталсан тогтоолын дагуу аливаа үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх;
- Гишүүн улс орнуудын хоорондын олон улсын шуудангийн үйлчилгээг зохион байгуулахад шаардлагатай нарийвчилсан журам бүхий олон улсын шуудангийн үйлчилгээний дүрмийг боловсруулж, батлах;
- Шуудангийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор гишүүн орнуудын шуудангийн байгууллагуудтай тогтмол харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх;
- Конгрессын хоорондох хугацаанд боловсруулсан захиргааны хэсгийн

жилийн төсөв, санхүүгийн тайланг хэлэлцэж батлах;

- Дэлхийн шуудан холбоо (UPU), бүс нутгийн шуудангийн холбоо болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн агентлагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, уг байгууллагуудын хурлуудад оролцох төлөөлөгчийг томилох;
- Техникийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд АНДШХ-ны нэрийн өмнөөс ДШХ болон бусад олон улсын байгууллагуудтай гэрээ хэлцэл байгуулах эрхийг гишүүн орнуудын гуравны хоёрын олонхийн зөвшөөрлөөр олгох;
- Дэлхийн Шуудангийн Их хурлын өмнө хуралдаж, гишүүн орнуудын байр суурийг уялдуулах, санал солилцох;
- Холбооны баримт бичгүүдэд тусгагдаагүй, яаралтай шийдвэрлэх шаардлагатай захиргааны шинжтэй бусад асуудлыг гишүүн орнуудын олонхийн зөвшөөрлөөр түр хугацаанд хэрэгжүүлэх шийдвэр гаргах

Дээрх асуудлуудаар Улаанбаатар хотноо хуралдана.















алыраак орман аялдоочулар байна.

Шилер: Ион үчкөн зурь портосунан эртоттукта,  
балас акиререн зот калыктыг деналыт кийик

Ауузым: Балалыг тиймарт бүй асуудууд, на зирий үйи ажиллаартай  
шүүз кайбартыт ботко буг адоокоос доруйтоту арла килити абагыги ба  
дралый дараар жайымын тейи килрай үроте эраритоту. Тиймарт буг  
дралылаа кайран каллаалаа эртай.

Урмалы: Балалылаа каллаалаа эртай!

Балы баи багний алырарык п, брлар. Биртук үс, калы зире, цыфр алыар,  
цал үррөн тейтбортой балыра, дунин расийан алаи балыктын алыарот  
дралы алыга орт байна.

Буг юу тийи тадак б?

- ✓ Зубанцар калыкыт баласола - балын баыверуулаа, кт цуралийн  
бууныраас татлаалаа!
- ✓ Балыкыг тийи броттотуури алыар.
- ✓ Ион ит дралы алыарыт зоркоо
- ✓ Зиреи зурт килити
- ✓ Балыкы, алыары тийи

Зире буг адоокоос дралылаа каллаалаа буг цртыги кийи цр калык  
аыот дралы иин дралы, илгоон алытара 1 калык цртыг балык  
блырар кт килити алаи тийицтыг буг калыкынын дралылаа  
абагы тадак калытара дралылаа каллаалаа!

Зиле - Шотландия

Тай - дралыи талыкыуула, тиралаандын байлаа асуудуу

1. Балык ион юу б?
2. Калыкы дралы ион юу б?
3. Балык алыттык алыттык
4. Балык цралаан алыттык
5. Балык тиралаандын бүй асуудуу.

Тыкыла - црмалаа, дусраг калыкыт калык цр.

Обот: Балыкы Ит: Зиреи

Алы: 25 Алыттык: 1-р алыттык

Алы / Алыттык: Балык црмалаа / Ион: Балык алыттык

Калыкы багыла црмалаа дусраг: 91/91/85/28.

Шотландиянын калыкыт калык:

Балыкыт ион калыкыт алыттыкыт балыкыт ион: Ш Шотландия





## ШУУДАНГИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

2025 ОНЫ 5-Р САР

№	Аж ахуйн нэгжийн нэр	Эрхлэх үйлчилгээ, хамрах хүрээ	ТЗ дугаар
<b>ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦАА СУНГАСАН АЖ АХУЙН НЭГЖ</b>			
1	Бинчин хүү ХХК	Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Монгол Улс-БНСУ/	43200124
2	Ашид шуудан ХХК	Дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Шуудангийн нэмэлт үйлчилгээ/	43400064
3	Эйр пасифик ХХК	Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Монгол Улс - ХБНГУ/	43200125
<b>ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР АВСАН АЖ АХУЙН НЭГЖ</b>			
1	Хурд онцгой боломж карго ХХК	Дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэх	
2	Азийн зам ХХК	Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Монгол Улс - БНХАУ/	
3	Эн Экс Би смарт ложистик ХХК	Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Монгол Улс - БНХАУ/	
4	Си Эйч Би ави номад экспресс карго ХХК	Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Монгол Улс- Канад/	
5	Альфа карго ХХК	Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Монгол Улс - БНХАУ/	
<b>ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮЧИНГҮЙ БОЛСОН АЖ АХУЙН НЭГЖ</b>			
1	Шагнаа ХХК	Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх	43200192
2	Карголинк ХХК	Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх	43100008
3	Баянтүмбэ трейд ХХК	Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх	43200090



Харилцаа холбооны зохицуулах хороо  
Метро бизнес төв А-блок 5 давхар  
Д.Сүхбаатарын гудамж-13  
Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар 14201-0033

ШУУДАНГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР